



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/63/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn	Булган аймаг дахь Төрийн аудитын, дарга, тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ
Булган аймаг	Утас: 70342580 Цахим хаяг: Erdeneb@auditgov.mn
2023 он	Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
	Ахлах аудитор: Г.Намчинсүрэн Утас: 70342716 Цахим хаяг: Namchinsureng@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
Асуудлыг онцолсон хэсэг	Error! Bookmark not defined.
Аудитын гол асуудал	Error! Bookmark not defined.
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
4. АУДИТЫН ТАЙЛАН	18
4.1 Ерөнхий зүйл	18
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	21
5.3 Зөвлөмж.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ШЕЗ	Шүүхийн Ерөнхий зөвлөл

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.09 № 28
танай _____ ны № _____ т

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ШҮҮХИЙН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
П.ХИШИГДАВАА ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Булган аймгийн Шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн. Тухайн байгууллагын хувьд тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.12 -д хязгаарлалтад хамрагдаагүй.

Булган аймаг дахь шүүхийн тамгын газрын 4 хөтөлбөр, 10 арга хэмжээний хүрээнд нийт 1,326.4 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж гүйцэтгэлээр 1,303.5 сая төгрөгийг зарцуулж хөтөлбөр, арга хэмжээний биелэлт 97 хувьтай байна.

Жилийн эцсээр 36.0 сая төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

006020029

Бараа материалын дансны бичиг хэргийн ангилалд харьяалах дээд байгууллагаас шилжүүлэн авсан программыг бүртгэсэн, байгууллагын тээврийн хэрэгсэлд бусад тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглээгүй зэрэг алдаа, зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн холбогдох заалыг зөрчжээ.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,672,014.00</u>	<u>9,387,474.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	3,840,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	00.00	3,840,000.00
3121	Төгрөг	00.00	3,840,000.00
31211	Төрийн сангийн харилцах	00.00	3,840,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	2,672,014.00	5,547,474.00
354	Хангамжийн материал	2,672,014.00	5,547,474.00
35410	Бичиг хэргийн материал	1,239,114.00	692,460.00
35420	Аж ахуйн материал	1,344,900.00	4,834,600.00
35440	Түлш, шатах тослох материал	88,000.00	20,414.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>772,356,502.71</u>	<u>763,979,299.56</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	772,356,502.71	763,979,299.56
392	Биет хөрөнгө	744,336,252.51	736,023,424.30
39201	Барилга, байгууламж, орон сууц	645,163,298.71	645,163,298.71
39202	Хуримтлагдсан элэгдэл	-81,115,990.56	-108,154,654.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	155,800,000.00	109,800,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-90,922,222.24	-29,755,555.62
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	139,578,991.82	153,544,172.36
39206	Хуримтлагдсан элэгдэл	-64,378,871.29	-76,830,608.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,234,109.98	71,595,295.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-33,107,611.43	-39,729,493.79
39214	Бусад үндсэн хөрөнгө	14,778,446.76	14,778,446.76
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,015,731.24	-5,354,308.32
39217	Ном	321,832.00	966,832.00
393	Биет бус хөрөнгө	28,020,250.20	27,955,875.26
39301	Програм хангамж	1,825,000.00	1,550,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,068,749.80	-858,124.74
39303	Бусад биет бус хөрөнгө	27,264,000.00	27,264,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>775,028,516.71</u>	<u>773,366,773.56</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>775,028,516.71</u>	<u>773,366,773.56</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	775,028,516.71	773,366,773.56
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	633,641,738.98	633,641,738.98
51101	Өмч: - төрийн	633,641,738.98	633,641,738.98
512	Хуримтлагдсан үр дүн	-156,355,424.09	-158,017,167.24
51210	Өмнөх үеийн үр дүн	-156,355,424.09	-156,355,424.09
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-1,661,743.15
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	297,742,201.82	297,742,201.82
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>775,028,516.71</u>	<u>773,366,773.56</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,033,454,430.00	1,404,401,587.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	84,279,830.00	64,795,487.36
120	Нийтлэг татварын бус орлого	84,279,830.00	64,795,487.36
120009	Бусад орлого	664,000.00	34,277,019.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	83,130,174.00	28,206,598.36
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	485,656.00	2,311,870.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	949,174,600.00	1,339,606,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	949,094,600.00	1,326,446,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	949,094,600.00	1,326,446,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,000.00	13,160,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	8,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,500,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	80,000.00	160,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,024,531,342.08	1,406,063,330.51
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,024,531,342.08	1,406,063,330.51
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,009,092,088.20	1,366,883,687.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	690,391,545.29	981,565,055.99
210101	Үндсэн цалин	533,900,351.47	657,459,108.00
210102	Нэмэгдэл	109,424,907.00	247,132,005.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,389,500.00	37,974,997.99
210104	Урамшуулал	24,676,786.82	38,998,945.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,473,999.53	123,055,150.11
210201	Тэтгэврийн даатгал	62,824,504.79	83,937,476.14
210202	Тэтгэмжийн даатгал	6,975,372.15	9,870,303.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,513,099.80	7,839,123.13
210204	Ажилгүйдлийн даатгал	2,700,668.01	1,946,204.18
210205	Эрүүл мэндийн даатгал	12,460,354.78	19,462,042.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,607,692.31	77,699,336.12
210301	Гэрэл, цахилгаан	4,607,456.31	4,426,070.12
210302	Түлш, халаалт	45,592,800.00	69,162,720.00
210303	Цэвэр, бохир ус	4,407,436.00	4,110,546.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,457,208.54	60,060,959.52
210401	Бичиг хэрэг	19,830,684.00	23,695,434.00
210402	Тээвэр, шатахуун	16,444,900.00	16,282,465.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,577,200.00	13,256,580.52
210404	Ном, хэвлэл	00.00	465,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	645,000.00	421,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,959,424.54	4,832,820.00

210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,106,200.00
2105	Нормативт зардал	800,000.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,642,500.00	16,841,010.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,325,650.00	22,000.00
210604	Урсгал засвар	15,316,850.00	16,819,010.00
2107	Томилолт, зочны зардал	7,007,000.00	9,043,279.00
210702	Дотоод албан томилолт	7,007,000.00	9,043,279.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,891,500.45	16,496,995.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,115,518.95	13,088,337.74
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,162,000.00	2,573,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	257,677.50	276,135.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	00.00
210807	Газрын төлбөр	42,804.00	39,123.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	78,820,642.08	82,121,901.51
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	78,820,642.08	82,121,901.51
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,439,253.88	39,179,642.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,998,600.00	3,160,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,998,600.00	3,160,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,440,653.88	36,019,642.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,440,653.88	36,013,242.52
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	8,923,087.92	-1,661,743.15
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	8,923,087.92	-1,661,743.15

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	949,174,600.00	1,344,606,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	5,000,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	5,000,000.00
120009	Бусад орлого	00.00	5,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	949,174,600.00	1,339,606,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	949,094,600.00	1,326,446,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	949,094,600.00	1,326,446,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	80,000.00	13,160,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	8,500,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,500,000.00

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	80,000.00	160,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	934,920,755.00	1,328,933,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	934,920,755.00	1,328,933,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	919,481,501.12	1,289,753,357.48
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	690,391,545.29	981,565,055.99
210101	Үндсэн цалин	533,900,351.47	657,459,108.00
210102	Нэмэгдэл	109,424,907.00	247,132,005.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,389,500.00	37,974,997.99
210104	Урамшуулал	24,676,786.82	38,998,945.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,473,999.53	123,055,150.11
210201	Тэтгэврийн даатгал	62,824,504.79	83,937,476.14
210202	Тэтгэмжийн даатгал	6,975,372.15	9,870,303.78
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,513,099.80	7,839,123.13
210204	Ажилгүйдлийн даатгал	2,700,668.01	1,946,204.18
210205	Эрүүл мэндийн даатгал	12,460,354.78	19,462,042.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	54,607,692.31	77,699,336.12
210301	Гэрэл, цахилгаан	4,607,456.31	4,426,070.12
210302	Түлш, халаалт	45,592,800.00	69,162,720.00
210303	Цэвэр, бохир ус	4,407,436.00	4,110,546.00
2104	Хангамж, бараа материалын зардал	48,819,113.54	57,178,530.52
210401	Бичиг хэрэг	17,486,000.00	21,559,280.00
210402	Тээвэр, шатахуун	12,624,900.00	15,642,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,577,200.00	13,256,580.52
210404	Ном, хэвлэл	00.00	465,960.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	645,000.00	421,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,486,013.54	5,832,350.00
2105	Нормативт зардал	800,000.00	2,874,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	2,874,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,490,650.00	16,841,010.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,325,650.00	22,000.00
210604	Урсгал засвар	15,165,000.00	16,819,010.00
2107	Томилолт, зочны зардал	7,007,000.00	9,043,279.00
210702	Дотоод албан томилолт	7,007,000.00	9,043,279.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,891,500.45	16,496,995.74
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,115,518.95	13,088,337.74
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,162,000.00	2,573,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	257,677.50	276,135.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	247,500.00	00.00
210807	Газрын төлбөр	42,804.00	39,123.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	5,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	5,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	15,439,253.88	39,179,642.52
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,998,600.00	3,160,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,998,600.00	3,160,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	10,440,653.88	36,019,642.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,440,653.88	36,013,242.52
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	6,400.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	14,253,845.00	15,673,100.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	14,253,845.00	11,833,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	14,253,845.00	11,833,100.00

2200	Дотоод эх үүсвэрээр	14,253,845.00	11,833,100.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	14,253,845.00	11,833,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-14,253,845.00	-11,833,100.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	3,840,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	3,840,000.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	633,641,738.98	297,742,201.82	-165,278,512.01	766,105,428.79
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	633,641,738.98	297,742,201.82	-165,278,512.01	766,105,428.79
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	8,923,087.92	8,923,087.92
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	633,641,738.98	297,742,201.82	-156,355,424.09	775,028,516.71
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	633,641,738.98	297,742,201.82	-156,355,424.09	775,028,516.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	633,641,738.98	297,742,201.82	-156,355,424.09	775,028,516.71
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-1,661,743.15	-1,661,743.15
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	633,641,738.98	297,742,201.82	-158,017,167.24	773,366,773.56

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,326,446,100.00	1,290,432,857.48	36,013,242.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,326,446,100.00	1,290,432,857.48	36,013,242.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,324,446,100.00	1,288,432,857.48	36,013,242.52
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,009,586,900.00	981,565,055.99	28,021,844.01
210101	Үндсэн цалин	680,601,700.00	657,459,108.00	23,142,592.00
210102	Нэмэгдэл	279,744,000.00	247,132,005.00	32,611,995.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	25,974,000.00	37,974,997.99	(12,000,997.99)
210104	Урамшуулал	23,267,200.00	38,998,945.00	(15,731,745.00)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,198,400.00	123,055,150.11	3,143,249.89
210201	Тэтгэврийн даатгал	85,814,900.00	83,937,476.14	1,877,423.86
210202	Тэтгэмжийн даатгал	10,095,900.00	9,870,303.78	225,596.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,076,700.00	7,839,123.13	237,576.87
210204	Ажилгүйдлийн даатгал	2,019,200.00	1,946,204.18	72,995.82
210205	Эрүүл мэндийн даатгал	20,191,700.00	19,462,042.88	729,657.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,940,200.00	77,699,336.12	1,240,863.88
210301	Гэрэл, цахилгаан	5,625,800.00	4,426,070.12	1,199,729.88
210302	Түлш, халаалт	68,900,000.00	69,162,720.00	(262,720.00)
210303	Цэвэр, бохир ус	4,414,400.00	4,110,546.00	303,854.00
2104	Хангамж, бараа материалын зардал	57,389,200.00	57,373,530.52	15,669.48
210401	Бичиг хэрэг	21,986,000.00	21,559,280.00	426,720.00
210402	Тээвэр, шатахуун	16,076,000.00	15,382,860.00	693,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,737,200.00	13,256,580.52	(2,519,380.52)
210404	Ном хэвлэл	1,000,000.00	920,960.00	79,040.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	690,000.00	421,500.00	268,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,900,000.00	5,832,350.00	1,067,650.00
2105	Нормативт зардал	800,000.00	474,000.00	326,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	474,000.00	326,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000,000.00	18,995,510.00	4,490.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,995,650.00	4,350.00
210604	Урсгал засвар	14,000,000.00	13,999,860.00	140.00
2107	Томилолт, зочны зардал	9,109,100.00	9,043,279.00	65,821.00
210702	Дотоод албан томилолт	9,109,100.00	9,043,279.00	65,821.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,422,300.00	15,226,995.74	3,195,304.26
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,950,000.00	11,818,337.74	3,131,662.26
210802	Аудит баталгаажуулалт зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,573,400.00	2,573,400.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	325,900.00	276,135.00	49,765.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00	0.00
210807	Газрын төлбөр	53,000.00	39,123.00	13,877.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	0.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	2,000,000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00	0.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,326,446,100.00	1,290,432,857.48	36,013,242.52
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,326,446,100.00	1,290,432,857.48	36,013,242.52
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,326,446,100.00	1,290,432,857.48	36,013,242.52
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		0.00	0.00
	Төсвийн бусад мэдээллийн ангилал			0.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	37	37	0.00
620001	Удирдах ажилтан	5	5	0.00
620002	Гүйцэтгэх ажилтан	27	27	0.00
620003	Үйлчлэх ажилтан	5	5	0.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	37	37	0.00
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15	15	0.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	11	11	0.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11	11	0.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	13,160,000.00	13,153,600.00	6,400.00
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	13,160,000.00	13,153,600.00	6,400.00
210	Бараа, үйлчилгээний зардал	13,160,000.00	13,153,600.00	6,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	260,000.00	260,000.00	0.00
210402	Тээвэр шатахуун	260,000.00	260,000.00	0.00
2105	Норматив зардал	2,400,000.00	2,400,000.00	0.00
210503	Нормын хувцас зөөлөн эдлэл	2,400,000.00	2,400,000.00	0.00
2106	Эд хогшил худалдан авах	9,230,000.00	9,223,600.00	6,400.00
210601	Багаж техник хэрэгсэл	710,850.00	710,850.00	0.00
210602	Тавилга	5,700,000.00	5,693,600.00	6,400.00
210604	Урсгал засвар	2,819,150.00	2,819,150.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,270,000.00	1,270,000.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,270,000.00	1,270,000.00	0.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	13,160,000.00	13,153,600.00	6,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,160,000.00	13,153,600.00	6,400.00
131103	ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,500,000.00	8,500,000.00	0.00

131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,500,000.00	4,493,600.00	6,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	160,000.00	160,000.00	0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			0.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			0.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газар нь шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд хөндлөнгөөс оролцохгүйгээр шүүгчийн хараат бус байдлыг хангаж хамгаалах, шүүхийн захиргааны үйл ажиллагааг удирдах, шүүхийн хүний нөөцийг удирдах, шүүхийн төсөв санхүү, дэд бүтцийг удирдах, шүүхийн нээлттэй байдлыг хангаж олон нийттэй харилцах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг.

Тус шүүхийн тамгын газар нь 2022 онд Шүүхийн тухай хууль тогтоомж түүнтэй холбогдон гарах дүрэм журмын шинэчлэлд үр нөлөөтэй санал, судалгааг гарган ШЕЗ-д хүргүүлэх тэдгээрийн хэрэгжилтийг хариуцлагатай зохион байгуулах шүүн таслах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, иргэдэд хүргэх шүүхийн үйлчилгээний нээлттэй ил тод байдлыг хангах, шүүхийн үйлчилгээний чанар, үр өгөөжийг сайжруулах, мэдээллийн цахим болон биет орчинг сайжруулж мэдээллийн үр нөлөөг нэмэгдүүлэх зорилтуудыг дэвшүүлэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, төсвийн ерөнхийлөн захирагчтай 46 арга хэмжээ зохион байгуулахаар байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.

Монгол улсын шүүхийн тухай /шинэчилсэн найруулга/ хуулийн дагуу шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаа, шүүгчид тавих болзол, шаардлага, шүүгчийн бүрэн эрх, эрх зүйн байдал, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлж хэрэгжүүлэн ажиллаж байна.

2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн 33 дугаар тогтоолоор Анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газрын үйл ажиллагааг үнэлэх журам батлагджээ. Үүнд: шүүхийн бие даасан байдал, хүний нөөц, хараат бус байдал, санхүү эдийн засгийн баталгааг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээ.

Тус шүүх нь 2022 онд нийт 1592 хэрэг, маргааныг анхан болон давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэж тэмдэгтийн хураамж болон торгох ялаар шийтгэгдсэний 266,930,000 төгрөгийг төрийн санд оруулжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын мөрдлөг болгон мөрддөг нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт нь 2020 оны 12 сарын 22-ны 174 дугаар тушаалаар шинэчлэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн хяналт шалгалт, үнэлгээ дотоод аудитын алба жилд 1 удаа шаардлагатай тохиолдолд ирж шүүхийн тамгын газрын үйл ажиллагаа, санхүүд дотоод аудит хийгддэг байна.

Иймд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

2021 онд төлөвлөгөөний дагуу дотоод аудитын хяналт шалгалт орж зөрчилгүй дүгнэгдсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын Шүүхийн Ерөнхий зөвлөлийн даргын 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 174 дүгээр тушаалаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөн санхүүгийн тайлангийн бүртгэл хөтөлдөг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт, байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,661.8 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		Өөрчлөлт
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	3,840.0	3,840.0
Авлага	0	0	0
Бараа материал	2,672	5,547.5	2,875.5
Үндсэн хөрөнгө	772,356.5	763,979.2	(8,377.3)
Нийт хөрөнгө	775,028.5	773,366.7	(1,661.80)
Өр төлбөр	0		
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	633,641.7	633,641.7	0
Дахин үнэлгээний зөрүү	297,742.2	297,742.2	0
Хуримтлагдсан үр дүн	(156,355.4)	(158,017.2)	(1,661.80)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	775,028,5	773,366.7	(1,661.80)

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгийн данс 3,840.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь тус байгууллага ахмадын сан байгуулж ахмад санд 5,000.0 мянган төгрөг төвлөрүүлж 1,160.0 мянган төгрөг зарцуулж үлдэгдэл үлдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын данс 5,547.5 мянган төгрөг болж 2,875.5 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал 3,489.7 мянган төгрөгөөр өсөж бичиг хэргийн материал 546.6 мянган төгрөгөөр, түлш шатах тослох материал 67.6 мянган төгрөгөөр тус тус буурсан нь төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотой. Тайлангийн хугацаанд 21,559.3 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 8,913.6 мянган төгрөгийн аж ахуйн материал, 15,642.9 мянган төгрөгийн шатах тослох материал, 2,899.6 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 41.2 мянган төгрөгийн эм, 9,964.6 мянган төгрөгийн барилгын материал нийт 59,021.2 мянган төгрөгийн бараа материал худалдан, ШЕЗ-өөс 2,311.87 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн материал шилжүүлэн, 572 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг тус тус авч 23,695.4 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 5,040.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 16,282.4 мянган төгрөгийн шатах тослох материал, 41,2 мянган төгрөгийн эм, 2,899.6 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 9,964.6 мянган төгрөгийн барилгын материал нийт 57,923.4 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Мөн шүүхийн тамгын газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн А/52 тушаалаар 1,106.2 мянган төгрөгийн бичиг хэрэг, аж ахуйн материалыг акталсан байна.

Үндсэн хөрөнгө дансанд тайлангийн хугацаанд шүүхийн ерөнхий зөвлөлөөс тавилга, тоног төхөөрөмж, ном эмхэтгэл нийт 28,206.6 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, 11,833.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил, компьютер принтер түүний дагалдах хэрэгслийг төсвийн хөрөнгөөр худалдан авч, 33,705 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмжүүдийг ТӨБЗГ-ын 2022 оны 06 сарын 09-ны өдрийн 287, 2022 оны 12 сарын 19-ны өдрийн 604 дугаар тогтоолын дагуу ашиглалтын хугацаа сунган, үнийг шинэчлэн тогтоож нийт 73,744.7 төгрөгийн хөрөнгө нэмэгдэж ТӨБЗГ-ын 2022 оны 06 сарын 09-ны өдрийн 287,305, 2022 оны 12 сарын

19-ны өдрийн 604, 622 дугаар тогтоолуудын дагуу 96,048.3 мянган төгрөгийн элэгдэлээ бүрэн нөхсөн хөрөнгүүдийг акталж данснаас хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 633 641.7 мянган төгрөг хэвээр, өмнөх үеийн үр дүн (156,355.4) мянган төгрөгийн алдагдалтай байсан ба тайлангийн хугацаанд (1,661.8) мянган төгрөгийн алдагдалтай ажиллаж хуримтлагдсан үр дүн (158,017.2) мянган төгрөгөөр тайлагнасан

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,386,000.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 400,500.0 мянган төгрөгөөр бууруулж, 985,500.0 мянган төгрөгөөр баталсан байна. УИХ-аас баталсан шүүхийн шинэчилсэн хуулийн дагуу шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын үндсэн цалинг 100% нэмэгдүүлэх хуулийн дагуу төсвийн төслийг боловсруулсан. Мөн урсгал засвар болон тавилга, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх нөхцөл байдал үүссэнтэй холбоотой санал байсан бөгөөд төсвийн хязгаарлагдмал байдлаас болоод шийдвэрлэгдээгүй байна.

Тайлант онд төсвийн хуваарьт Шүүхийн Ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн өөрчлөлтийн дагуу 3 удаа өөрчилөлт хийж 340,946.0 мянган төгрөгөөр өсгөж, 1,326,466.0 мянган төгрөгөөр баталжээ. Энэ нь хуулийн хэрэгжилтийн дагуу шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарын цалинг 5 сараас эхлэн 100% нэмэгдүүлэн тооцсонтой холбоотой.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 340,946.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 4 хөтөлбөр, 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,326,446.0 мянган төгрөг улсын төсвөөс, өөрийн үйл ажиллагаанаас 4,600.0 мянган төгрөг, засаг даргын нөөц хөрөнгөнөөс 8,500.0 мянган төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,326,466.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, үйл ажиллагааны орлого 13,160.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

2022 оны төсөв 1,326.4 сая төгрөгөөр батлагдаж, 1,326.4 сая төгрөгийн зарцуулах эрхийн санхүүжилт орж, 10 бүлгийн 30 нэр төрлийн зардалд зарцуулж, төсвийн мөнгөний зарцуулалтад хуулийн хүрээнд хяналт тавьж, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаа. Жилийн нийт төсвийн 85%-ийг Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал эзэлж байна.

Мөн цар тахал, төрийн хэмнэлтийн хуулийн дагуу зарим зардал буурсан, бараа материалын үнэ өсөж зардлын зүйл бүр дээр биш бүлэг дотроо хянаж гүйлгээ хийж зарим тохиолдолд бусад бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээгээ хязгаарлах нь хүндрэлтэй байсан ч асуудлыг тухай бүр нь шийдвэрлэж шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал, шүүн таслах үйл ажиллагааг хэвийн явуулж өр, авлагагүй тайлагнасан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,304,700.0 мянган төгрөг буюу 97 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 36,013.2 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулж улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн. Давж заалдах шатны шүүхийн шүүгч өндөр насны тэтгэвэрт гарснаас орон тоо дутуу ажилласан байна. Улсын төсвөөс орж ирсэн урсгал үйл ажиллагааны санхүүжилтээс 5,000.0 мянган төгрөгөөр ахмадын сан байгуулсан.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
		/мянган төгрөгөөр/			
1	Үндсэн үйл ажиллагаа	1,317,246.1	1,284,311.3	32,934.8	97%
	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,009,586.9	981,565	28,021.9	97%
	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	126,198.4	123,055.2	3,143.2	97%
	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	78,940.2	77,699.4	1,240.8	98%
	Хангамж, бараа материалын зардал	57,389.2	57,373.5	15.7	99%
	Норматив зардал	800,0	474,0	326	89%
	Эд хогшил худалдан авах зардал	19,000	18,995.5	4.5	99%
	Томилолт	9,109.1	9,043.3	65.8	99%
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,222.3	11,105.4	116.9	83%
	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000	5,000	0	100%
2	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	2,000	2,000	0	100%
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	2,000	2,000	0	100%
3	Зөвлөл хороо комиссийн гишүүд	6,000	3,571.5	2,428.5	59.5%
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,000	3,571.5	2,428.5	59,5%
4	Шинжээч, орчуулагч хэлмэрчийн төлбөр	1,200	550.0	650.0	45.8%
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,200	550.0	650.0	45,8%
5	Нэмэлт санхүүжилт	13,160	13,153.6	6.4	100%
	Хангамж, бараа материалын зардал	260	260	0	100%
	Норматив зардал	2,400	2,400	0	100%
	Эд хогшил худалдан авах зардал	9,230	9,223.6	6.4	100%
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,270	1,270	0	100%
6	Ахмадын сан	5,000	1,160	3,840	23.2%
	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	5,000	1,160	3,810	23.2%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 13,160,000 төгрөгийн орлогыг хүлээн авч 13,153,600 төгрөгийн гүйцэтгэлтэйгээр 4 бүлгийн 6 нэр төрлийн зардалд зарцуулж 6,400 төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна. ШЕЗ өөрийн давсан орлогоос хуваарилсан 4,5 сая төгрөг, шүүхийн шийдвэрийн дагуу 160 мянган төгрөг, засаг даргын нөөц хөрөнгөнөөс 6,5 сая төгрөгийг тус тус хүлээн авч зарцуулах эрхийн хүсэлтийг санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлж шийдвэрлүүлэн зарцуулагджээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах дансны ангилал, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Намчинсүрэн, аудитор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр бусд буюу тайлант

оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсөв 1,326.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 19,896.7 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын ахлах нягтлан бодогч төрийн хэмнэлтийн хуулиар бүх ажилчдад сургалтыг зохион байгуулж хэмнэгдэж болох зардал болон тэвчих зардлууд дээр санал бодлоо солилцон ажилласан. Ажилчид бичгийн хэрэгслийн зардлыг хэмнэх, гэрэл цахилгааныг бүрэн унтрааж явах, усны алдагдал гаргахгүй байхын тулд слесарь тухай бүр нь үзлэг хийн тэмдэглэл хөтлөх зэрэг арга хэмжээнүүд авч ажилласан.

Үүнтэй холбоотойгоор гэрэл цахилгааныг 1,199 мянган төгрөгөөр, цэвэр бохир усыг 303 мянган төгрөгөөр, бичиг хэргийн зардлыг 426.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган аймаг дахь Шүүхийн тамгын газар нь шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан 14 удаагийн нийт 1,312,246.0 мянган төгрөгийн орлогын мэдээлэл, 29 удаагийн 249,793.0 мянган төгрөгийн зарлагын мэдээлэл, 6.4.8-д заасан 87 удаагийн 48,900.0 мянган төгрөгийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлсэн байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 зугаар зүйлийн 6.4-д “Байгууллагын авто тээврийн хэрэгсэлд бусад авто тээврийн хэрэгслээс ялгагдах тод дэвсгэр өнгө бүхий улсын дугаар хэрэглэнэ” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6.4-д заасан заалтыг хэрэгжүүлэн ажиллах

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын дансны аж ахуй материалын дансны ангилалтай холбоотой 1 зөвлөмжийг хүргүүлсэнг бүрэн хэрэгжүүлэн хариуг 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 175 тоот албан бичгээр хариу ирүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		/мянган төгрөгөөр/ Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0			
Албан шаардлага	0	0			
Зөвлөмж	1	0	1	0	100
Нийт дүн	1	0	1	0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шүүхийн тусгай архивын 2022 оны 05 дугаар сарын 17 -ны өдрийн 1/1320 тоотоор ирүүлсэн чиглэлийн дагуу шүүхийн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд гэрээт ажилтнаар 1 хүн ажиллуулж цалингийн зардалд 5,760.0, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардалд 777.6 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн ангиллаас зарцуулсан нь Монгол Улсын сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлыг эдийн ангилал ашиглах заавар”-ыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад бараа материалын дансны ангиллыг буруу бүртгэсэн 1,600.0 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын холбоотой асуудал

Илрүүлэлт: Бараа материалын дансны бичиг хэргийн ангилалд харьяалах дээд байгууллагаас шилжүүлэн авсан вирусийн программыг бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3, 4.4 дэх заалт, УСНББОУС-12, санхүүгийн тайлангийн аудитын үнэлгээ ба хуваарилалт батламж мэдээдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Бараа материалын ангиллыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3, 4.4 дэх заалт, УСНББОУС-12-д заасны дагуу ангилан бүртгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/ Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бараа материалын дансны бичиг хэргийн ангилалд харьяалах дээд байгууллагаас шилжүүлэн авсан вирусийн программыг бүртгэсэн	1	1,600.0										
Дүн	1	1,600.0										

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

